

“ХИЙН ХАНГАМЖ” /БНБД 42-01-19/ БАРИЛГЫН НОРМ БА ДҮРМИЙГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо Дүнжингарав худалдааны төвийн уулзвар дээр 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр шингэрүүлсэн хий тээвэрлэж явсан автомашин дэлбэрсний улмаас учруулсан үр дагавар, нөлөө, хохирлыг тооцох Улсын Онцгой комиссын нарийн бичгийн даргын удирдамжийн дагуу Шатахуун түгээх станц, авто хийгээр цэнэглэх станцын барилга байгууламжид хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтаар: Монгол Улсын хэмжээнд нийт 1486 шатахуун түгээх станц (ШТС) болон автомашин хийгээр цэнэглэх станц (АХЦС), нийт 91 газрын тосны бүтээгдэхүүний агуулах (ГТБА) байна. Үүнээс ШТС, АХЦС 278, ГТБА-гийн 26 нь Улаанбаатар хотод байрлаж байна.

Нийт 91 ГТБА-ын 8-д хяналт шалгалт хийхэд барилга хоорондын зай зөрчсөн зөрчил 2, нийт 1486 ШТС, АХЦС-ын 614-т хяналт шалгалт хийхэд барилга хоорондын зай зөрчсөн зөрчил 69 илэрсэн байна.

Ажлын хэсгээс гарсан дүгнэлтэд: орон сууц, хүүхдийн байгууллага, эмнэлгээс ШТС хүртэлх хамгийн бага зайг барилга байгууламжийн норм, норматив баримт бичигт 25м байхаар заасан нь сургууль, цэцэрлэг, эмнэлгийн гадна орчинд шатахуун ууршиж үнэртэх, галын аюул осол үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна. Нийслэлийн нутаг дэвсгэрт 57 АХЦС үйл ажиллагаа явуулж байгаагаас 30 нь ил сав ашиглаж байгаа нь “Хий хангамж” /БНБД 42-01-19/-ийн 8.124-т заасны дагуу Хот суурин газар АХЦС-ын савнуудын нийт багтаамж 10м^3 -ээс бага тохиолдолд газар дээр ил, түүнээс илүү бол газар доор байрлуулбал зохино гэсэн заалтыг хангаж байгаа боловч хий алдагдсан тохиолдолд галын аюул осол үүсэх эрсдэлтэй байна.

Иймд Барилга, хот байгуулалтын яаманд дараах чиглэлийг өгсөн. Үүнд:

- “Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм” /БНБД 21-07-14/-ийн 5.8 дахь заалт: Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хүүхдийн байгууллагын барилга, орон сууц, олон нийтийн барилгын зай хэмжээ 25м-ийг өөрчилж 50м болгох, мөн тус нормын 19.1 дэх заалт: Олон төрлийн түлш түгээх станцад далд савтай ердийн ШТС-ын технологийн системийн шаардлагыг хангасан шатахуун хүлээн авах, хадгалах ба түгээх технологийн систем ашиглахыг зөвшөөрнө гэснийг өөрчлөлт оруулж ШТС, АХЦС хамтдаа байхыг тус тусд нь төлөвлөх гэх, мөн тус нормын 7-р хүснэгтэд ШНУХ-тэй бол орон сууц, олон нийтийн барилга байгууламжаас 60м,

- “Хийн хангамж” /БНБД 42-01-19/-ийн 22-р хүснэгтэд ил савтай 10м^3 бол 18м гэж зөрүүтэй заагдсан заалтыг өөрчлөх, 8.124 заалтад: Хот суурин газар АХЦС-ын савнуудын нийт багтаамж 10м^3 -ээс бага тохиолдолд газар дээр ил, түүнээс илүү бол газар доор байрлуулвал зохино гэснийг Хот суурин газрын АХЦС-ын савны багтаамж харгалзахгүй далд байрлуулах гэж өөрчлөх,

- “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах. Галын аюулгүйн норм” /БНБД 21-03-04/-ийг шинэчлэн батлуулах шийдвэр гарсан.

Дээрх дүгнэлт шийдвэрийн дагуу газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын барилга байгууламжид галын аюулгүй байдлын шаардлагыг шинээр барих, сэргээн засварлах, их засвар хийх зураг төсөл зохиоход мөрдөх норматив баримт бичигт дотоодын хяналтыг сайжруулах, хэрэглэгчдэд учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ОХУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй материалд СП 155.13330.2014 “Склады нефти и нефтепродуктов. Требования пожарной безопасности”-г эх материал болгон ашиглаж, Засгийн газрын 2023 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-тай уялдуулан ”шинэчлэн боловсруулна.

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

БАТЛАВ.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.БАЯРБАТ

**“ХИЙН ХАНГАМЖ” /БНБД 42-01-19/ БАРИЛГЫН НОРМ БА ДҮРМИЙГ
ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

2024 оны 07 дугаар
сарын 02-ний өдөр

Дугаар 02/2024

Улаанбаатар хот

Төсөл боловсруулах үндэслэл	“Барилгын тухай хууль”-ийн 33 дугаар зүйл 33.1.2 дугаар заалт; Улсын Онцгой Комиссын 2024 оны 4 дүгээр хурлын шийдвэр; Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо”; Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2024 оны төлөвлөгөөний Б-2-1-ийн 6.4 дэх заалт.
Төслөөр шийдвэрлэх асуудлууд	1.2 МПа-аас илүүгүй даралттай байгалийн хий (CNG) болон шингэрүүлсэн хий, 1.6 МПа-аас илүүгүй даралттай шингэрүүлсэн нүүрсустөрөгчийн хий (LPG)-ээр хангах зориулалттай хий түгээх сүлжээ, хийн хэрэглээний байгууламжийг шинээр барих, сэргээн засварлах, их засвар хийх зураг төсөл зохиоход мөрдөх норматив баримт бичигт Улсын Онцгой Комиссын 2024 оны 4 дүгээр хурлын шийдвэрийн дагуу Шатахуун түгээх станц, авто хийгээр цэнэглэх станцын барилга байгууламжид хяналт шалгалт хийсэн дүгнэлтийн дагуу шинэчлэн боловсруулна.
Төслийн бүрдэл	1. Хэрэглэх хүрээ; 2. Норматив эшлэл; 3. Нэр томъёо, тодорхойлолт; 4. Хий хангамжийн төлөвлөлтөд тавигдах ерөнхий шаардлага; 5. Хий дамжуулах гадна хоолой; 5.1 Ерөнхий зүйл; 5.2 Хий дамжуулах газар доорх хоолой; 5.3 Хий дамжуулах ил хоолой; 5.4 Ус, гуу жалгатай газрын хий хоолой; 5.5 Төмөр зам болон авто зам доорх хийх дамжуулах хоолой; 5.6 Онцгой нөхцөлд хий дамжуулах хоолойд тавигдах нэмэлт шаардлага; 5.7 Газар доорх хий дамжуулах ган хоолойг сэргээн засварлах; 6. Хий хуваарилах цэг ба хий хуваарилалтыг хэмжих цэг; 6.1 Ерөнхий зүйл; 6.2 Хийн даралт хуваарилалт хэмжих цэгт тавигдах шаардлага; 6.3 Хий хуваарилах самбар (хайрцаг)-т тавигдах шаардлага;

	<p>6.4 Хий тохируулга; 6.5 Хий хуваарилах цэгийн тоног төхөөрөмж; 7. Хий дамжуулах дотор хоолой; 8. Шингэрүүлсэн хий хадгалах цилиндр сав суурилуулалт; 8.1 Савны суурилуулалт; 8.2 Савны ангилал болон суурилуулалт; 9. Хий цэнэглэх станц болон цэг, баллон хадгалах завсрын агуулах, автомашинд хий цэнэглэх станц; 9.1 Ерөнхий зүйл; 9.2 Хий түгээх цэгүүдийн байршил болон барилга байгууламжид тавигдах шаардлага; 9.3 Хий түгээх сав (LPG); 9.4 Хий цэнэглэх станцын инженерийн тоног төхөөрөмж; 9.5 Хий цэнэглэх цэг; 9.6 Баллон хадгалах завсрын агуулах; 10. Хий цэнэглэх станц (ХЦС)-ын барилгын чанарт хяналт тавих, хүлээн авах; 10.1 Ерөнхий зүйл; 10.2 Гадна хэмжилт ба хяналт, шалгалт; 10.3 Механик туршилт; 10.4 Физик шинж чанарын хяналт; 10.5 Хий дамжуулах хоолойн туршилт; 10.6 Хий цэнэглэх станцыг хүлээн авах; Хавсралт А. Хий цэнэглэх станцаас барилга байгууламж хүртэлх хамгийн бага зай хэмжээ; Хавсралт Б. Газар доорх хийн хоолойгоос барилга байгууламж хүртэлх хамгийн бага зай хэмжээ; Хавсралт В. Айл өрхийн хийн оролтыг хязгаарлах ердийн шийдэл; Хавсралт В*. Барилга байгууламжийг хийгээр цэнэглэх аюулгүй ажиллагаа; Хавсралт Г. Хий цэнэглэх байгууламжийг хүлээн авах акт.</p>
Төслийг хэрэгжүүлэгч байгууллага	Барилга, хот байгуулалтын яам Барилгын хөгжлийн төв
Төслийг гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэгчийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу сонгон шалгаруулна.
Төслийн боловсруулж дуусгах хугацаа	2025 оны IV улирал
Төсөлд шаардагдах хөрөнгийн хэмжээ	Урьдчилсан тооцоогоор нийт 33,336,352 төгрөгийг “Барилга байгууламжийн норм, нормативын сан”-аас санхүүжүүлнэ.
Онцгой нөхцөл	<p>- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо”-ны шаардлагыг хангасан байна.</p> <p>- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 98 дугаар</p>

	<p>тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-тай уялдуулан шинэчлэн боловсруулна.</p> <ul style="list-style-type: none"> - Техникийн даалгаврын төслийн бүрдэлд тусгагдсан агуулгатай байхаас гадна боловсруулалтын явцад төслийг ойлгомжтой, эмх цэгцтэй, нэмэлт мэдээлэл тусгагдахаар сайжруулалт хийх тохиолдолд захиалагчийн зөвшөөрлөөр өөрчлөлт орж болно. - Боловсруулагдаж байгаа баримт бичигтэй холбоотойгоор Монгол улсын барилгын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, нормативын баримт бичиг, стандартын давхцалтай болон зөрүүтэй ойлголтыг засварлах саналыг захиалагчид зөвлөмж байдлаар ирүүлэх. Мөн дээр дурдсан баримт бичигт хүчингүй болгох заалтын талаар зөвлөмж ирүүлэх. - Суурь материалд СП 62.13330.2011* “Газораспределительные системы”-г эх материал болгон боловсруулалт хийнэ.
--	---

**“ХИЙН ХАНГАМЖ” /БНБД 42-01-19/ БАРИЛГЫН НОРМ БА ДҮРМИЙГ
ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН УРЬДЧИЛСАН ТӨСӨВ**

№	Хийх ажлын нэр	Хөдөлмөр зарцуулалт /хүн, өдөр/			Шаардагдах зардал /төгрөг/	Хянасан
		Ажиллах хүн/өдөр	Нэгж хүн өдрийн үнэлгээ /төгрөг/	Зөвлөх багт ажиллах хүний тоо		
1	Олон улсад хэрэглэгдэж байгаа энэ төрлийн норматив баримт бичгийг судалж, танилцан үнэлэлт дүгнэлт гаргаж, эхний тайлан ирүүлэх	17	117,764	2	4,003,976	
2	Судалгааны материалын үр дүнг цэгцэлж эх материалыг Монгол хэлнээ хөрвүүлэх	17	117,764	2	4,003,976	
3	Хөрвүүлсэн ажлыг цэгцлэн бусад Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норматив баримт бичигтэй нийцүүлэн судалж, боловсруулж зөрүүтэй болон давхцалтай заалтуудыг	17	117,764	2	4,003,976	

	хэрхэн уялдуулах талаар захиалагчтай зөвшилцөх					
4	Боловсруулсан төслийг захиалагчийн шаардлагыг хангах түвшинд хянаж, төслийг бэлтгэж ирүүлэх	60	117,764	2	14,131,680	
Гүйцэтгэгчид олгох нийт мөнгөн дүн					26,143,608	
5	Нормын төслийг хянан тохиолдуулах				2,000,000	
6	Нормын төсөлд шүүмж хийх				2,700,000	
7	Холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх зардал				1,000,000	
8	Салбарын шинжлэх, ухаан, техник, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх зардал				1,000,000	
9	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зардал				200,000	
БҮГД					33,043,608	
Бичиг хэргийн зардал					292,744	
НИЙТ ӨРТӨГ					33,336,352	✓
Тайлбар: Зөвлөхөд олгох 1 хүн өдрийн хөлсийг Үндэсний Статистикийн хорооны мэдээллээр 117,764 төгрөгөөр тооцов.						

ХЯНАСАН:

БХБЯ-НЫ БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
 ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА - 2

Д.ГАНТУЛГА

БХБЯ-НЫ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
 ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН
 АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.АРИУНСАНАА -2

БХБЯ-НЫ БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
 ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

О.БАЯРБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ”-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ТУС ТӨВИЙН НОРМ, НОРМАТИВЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТУС ТӨВИЙН НОРМ, НОРМАТИВЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ТУС ТӨВИЙН НОРМ, НОРМАТИВЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Д.АЛТАНХУЯГ

Н.БАТЖИЛМАА

A handwritten signature in blue ink, appearing to be "Г.Саруултуяа".

Г.САРУУЛТУЯА

A handwritten signature in blue ink, appearing to be "С.Болормаа".

С.БОЛОРМАА